



ЭКСПОРТЫН ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Боловсруулсан: ВЭЗГ, ТТССХ-ийн эдийн засагч Т.Түвшингэрэл

ХУРААНГУЙ

Монгол Улсын экспортын гадаад худалдаа өнгөрсөн 10 жилийн хугацаанд 7.1 дахин өсч, 2013 оны жилийн эцсийн байдлаар 4,272.7 сая ам.долларт буюу ДНБ-ий 38.2%-д хүрсэн. Энэ нь эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой үзүүлэлт хэдий ч банкны системээр дамжин орж ирж буй экспортын бодит орлого энэ түвшинд хүрч чадахгүй байна. Иймд энэхүү шинжилгээний ажлаар гадаад худалдааны барааны дэлгэрэнгүй статистик мэдээллийг голлох экспортын бараа бүтээгдэхүүний задаргаагаар нарийвчлан задлан үзэж, гэрээ болон гаалийн статистик дүнг банкны системээр дамжин орж ирэх экспортын орлого, ААНБ-ын санхүүгийн тайлан мэдээлэлтэй тулган үзэж бодит экспортын орлогыг тодорхойлохыг зорилоо.

Шинжилгээний үр дүнд гадаад худалдааны статистик мэдээлэл дахь экспортын бүртгэл нь гаалийн байгууллагын үнэлгээний арга хэрэгслээс шалтгаалан 2011 оны эхнээс 2014 оны 8 сар хүртэлх хугацаанд 1,869.8 сая ам.доллараар илүү үнэлэгдсэн нь тогтоогдсон. Төлбөрийн тэнцэл боловсруулах олон улсын аргачлалын дагуу төлбөрийн тэнцлийн барааны дансанд тусгах экспортын дүн мэдээ нь гаалийн байгууллагын аливаа үнэлгээний арга хэрэгслээс үл хамаарах, ААНБ-ын гэрээ, хэлцлийн дүн, бодит орлогод үндэслэсэн мэдээлэл байх шаардлагатай байдаг тул гаалийн статистик мэдээллийг төлбөрийн тэнцлийн барааны дансны статистикт тусгахдаа холбогдох тохируулгыг хийх шаардлагатай байна.

УДИРТГАЛ

Монгол Улсын экспортын гадаад худалдаа¹⁷² өнгөрсөн 10 жилийн хугацаанд 7.1 дахин өсч, 2013 оны жилийн эцсийн байдлаар 4,272.7 сая ам.долларт буюу ДНБ-ий 38.2%-д хүрсэн. Энэ нь эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой үзүүлэлт хэдий ч банкны системээр дамжин орж ирж буй экспортын бодит орлого энэ түвшинд хүрч чадахгүй байна. Тухайлбал 2013 оны байдлаар нийт экспортын орлогын 29.6% буюу 1,265.1 сая ам.долларын орлого банкны системийн урсгалаар дутуу орж ирсэн. Энэ нь нэг талаас экспортлогчийн орлого нь экспортын гэрээнд тусгагдсан (i) худалдааны төлбөрийн нөхцөл¹⁷³, (ii) бүтээгдэхүүн хуваах нөхцөл¹⁷⁴ болон (iii) экспортын орлогыг хаана байршуулахаас хамааран хугацааны болоод хэлбэрийн¹⁷⁵ өөрчлөлттэйгөөр орж ирэхээс шалтгаалж болно. Харин нөгөө талаас уул уурхайн экспорт давамгайлдаг манайх шиг орны хувьд гаалийн экспортын бүртгэл нь бодит экспортоос өндрөөр үнэлэгддэг байх эрсдэл байгааг харуулж байна.

Иймд энэхүү шинжилгээний ажлаар гадаад худалдааны барааны дэлгэрэнгүй статистик мэдээллийг голлох экспортын бараа бүтээгдэхүүний задаргаагаар нарийвчлан задлан үзэж, гэрээ болон гаалийн статистик дүнг банкны системээр дамжин орж ирэх экспортын орлого, ААНБ-ын санхүүгийн тайлан мэдээлэлтэй тулган үзэж бодит экспортын орлогыг тодорхойлохыг зорилоо.

Шинжилгээний ажлын нэгдүгээр хэсэгт төлбөрийн тэнцлийн барааны дансыг бүртгэх олон улсын аргачлал, манай орны экспортын худалдааны талаарх ерөнхий мэдээлэл, шинжилгээний өгөгдлийг, хоёрдугаар хэсэгт аргачлал болон тооцоолол, гуравдугаар хэсэгт үр дүнг танилцуулж эцэст нь санал, дүгнэлтийг тусгасан болно.

¹⁷² Гаалийн ерөнхий газраас бэлтгэн гаргадаг Гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл.

¹⁷³ Төлбөр тооцоо нь худалдааны зээл, бэлэн валютаар хийгдэх гэх мэт.

¹⁷⁴ Тухайлбал түүхий нефтийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газарт оногдох орлого нь нийт экспортын 32 орчим хувийг бүрдүүлж байна.

¹⁷⁵ Экспортын орлогын тодорхой хувийг бараа, үйлчилгээний импортын төлбөр, зээлийн эргэн төлөлт (тухайлбал Чалко)-д шууд болон шууд бусаар суутгуулах, шилжүүлэх.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Олон улсын туршлага

ОУВС-гийн төлбөрийн тэнцлийн 6-р аргачлалын дагуу барааны худалдаа гэж барааны эзэмшил харьяат болон харьяат бусын хооронд шилжсэн бүтээгдэхүүнийг хэлэх бөгөөд бүртгэлийг бараа нийлүүлэх FOB нөхцөлөөр буюу усан онгоцны тавцан хүргэх нөхцөлөөр бүртгэдэг¹⁷⁶. Өөрөөр хэлбэл тухайн экспортлогч нь өөрийн улсаас бүтээгдэхүүн гаргах хамгийн сүүлийн тээврийн хэрэгсэл хүртэл чөлөөтэй нэрлэсэн газарт бараа нийлүүлэх бүхий л хариуцлагыг хүлээх нөхцөлөөр бүртгэдэг байна. Гэвч экспортын энэ төрлийн бүртгэл нь тухайн улс орны онцлогоос хамааран хүндрэлтэй тохиолдолд хилийн боомт хүртэлх нөхцөлөөр бүртгэх нь тохиромжтой гэж заасан байна. Энэ нь манай орны экспортын барааны гаалийн үнийг тодорхойлдог Монгол улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлтэй¹⁷⁷ нийцтэй байна.

Ихэнх улс орнуудын хувьд Төлбөрийн тэнцлийн статистик дахь экспортын дансны мэдээллийн эх сурвалжаар гадаад худалдааны статистик мэдээллийг ашигласаар ирсэн боловч шаардлагатай тохиолдолд Схем 1-д тусгасан 4 чиглэлээр нэмэлт тохиргоо оруулж бүртгэдэг.

Схем 1: Гадаад худалдааны статистик мэдээлэлд тохиргоо оруулдаг үзүүлэлтүүд, түүний жишээ¹⁷⁸

Хамрах хүрээ	•Эзэмшил солигдсон боловч хилээр нэвтрээгүй бараа бүтээгдэхүүнийг нэмэх, •Эзэмшил солигдоогүй боловч хилээр нэвтэрсэн бараа бүтээгдэхүүнийг хасах гэх мэт.
Хугацаа	•Гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлтийн дамжин өнгөрөх процесс зэргээс хамааран хугацааны зөрүү үүссэн тохиолдолд холбогдох тохиргоог оруулах.
Ангилал	•Боловсруулах бараа бүтээгдэхүүнийг барааны данснаас хасч үйлчилгээний дансанд бүртгэх гэх мэт.
Үнэлгээ	•Гаалийн үнэлгээний аргачлал нь бодит гүйлгээний дүнтэй нийцгүй байх тохиолдол гардаг. Энэ нөхцөлд Төлбөрийн тэнцлийн барааны дансанд холбогдох тохиргоог хийх шаардлагатай.

¹⁷⁶ ОУВС-гийн төлбөрийн тэнцлийн 6-р аргачлал, 2009, хуудас 156.

¹⁷⁷ Гаалийн тариф, гаалийн татварын тухай Монгол Улсын хуулийн тавдугаар бүлгийн 16 дугаар зүйл.

¹⁷⁸ Balance of payments compilation guide, IMF, 1995

1.2 Монгол Улсын туршлага, нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт орох хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, томоохон уурхайнуудын үйл ажиллагаа эхэлснээр ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт болон экспорт огцом өссөн. Хэдий тийм ч банкны системээр дамжин орж ирэх экспортын бодит орлого нь гаалийн экспортын дүнгээс 2011-2014 оны хооронд 16-42%-иар дутуу байгаа тул энэ зөрүүг тайлбарлах шаардлага гарсан. Экспортын орох урсгал нь түүхий нефтийн бүтээгдэхүүн хуваах гэрээ, Монголбанкны худалдсан алт, экспортлогчийн худалдааны төлбөрийн нөхцөл гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалан гаалийн экспортын дүнтэй заавал таарах шаардлагагүй.

Зураг 1: Гаалийн экспорт, орлогын урсгал



Гэвч дээрх тохируулгуудыг хийсний дараа ч экспортын орлогын зөрүү гарсаар байсан тул Гаалийн ерөнхий газраас бэлтгэн гаргадаг гадаад худалдааны статистик мэдээлэлд шинжилгээ хийж, ААНБ-ын санхүүгийн тайлан баланс, төлбөрийн тэнцлийн мэдээ¹⁷⁹, арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлантай тулган үзэж бодит орлогыг тодорхойлох шаардлага гарсан.

Манай оронд гадаад худалдааны статистик мэдээллийг боловсруулах эрх, үүргийг хуулийн дагуу Гаалийн ерөнхий газар хариуцдаг бөгөөд экспортлогчдын гаалийн мэдүүлэгт үндэслэн нэгтгэн гаргадаг. Хэрэв гаалийн мэдүүлэг нь бүрэн бус, дэлхийн зах зээл дээх үнэлгээнээс хэт доогуур тавигдсан гэж үзсэн тохиолдолд гаалийн байгууллага нь үнэлгээний бусад арга хэрэгслүүд /Шигтгээ 1/-ийг ашиглаж үнийн дүнг тодорхойлон, статистикийг нэгтгэдэг.

Харин төлбөрийн тэнцлийн барааны дансанд тусгах экспортын дүн мэдээ нь гаалийн байгууллагын аливаа үнэлгээний арга хэрэгслээс үл хамаарах, ААНБ-ын гэрээ, хэлцлийн дүн, бодит орлогод үндэслэсэн мэдээлэл байх шаардлагатай юм.

¹⁷⁹ Монголбанк нь Монгол улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2010 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1/174 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу голлох ААНБ-аас улирал бүр мэдээ авдаг.

Шигтгээ 1: Судалгаанд хамаарал бүхий хуулийн заалтууд**Гаалийн тариф, татварын тухай Монгол улсын хууль:**

Нэгдүгээр бүлэг 2 дугаар зүйлийн 3.1: Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.4 “гаалийн үнэ” гэж гаалийн татвар ногдуулах, гаалийн статистикийн мэдээлэл гаргах зорилгоор энэ хуулийн дагуу тодорхойлох үнийг,

Гуравдугаар бүлэг 8 дугаар зүйлийн 8.3: Гаалийн байгууллага нь дараах тохиолдолд бодит мэдээллийг үндэслэн гаалийн үнийг мэдүүлэгчийн тодорхойлсноос өөр аргаар тодорхойлж болно:

8.3.1 гаалийн үнийг тодорхойлоход ашигласан бичиг баримт баталгаажаагүй, эсхүл түүнд тусгагдсан мэдээлэл зөрсөн, бүрэн бус, тоон үзүүлэлт нь хангалтгүй байсан бол,

8.3.2 мэдүүлэгч гаалийн үнийн үнэн зөвийг нотолж чадаагүй бөгөөд гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон үнийг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд

Тавдугаар бүлэг 16 дугаар зүйлийн 16.2: Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход дараах аргыг дор дурдсан дарааллын дагуу хэрэглэнэ:

16.2.1 хэлцлийн үнийн арга;

16.2.2 зардлаас тооцох үнийн арга;

16.2.3 нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга;

16.2.4 зах зээлийн мэдээлэл, судалгааны арга.

1.3 Шинжилгээний өгөгдөл

Уг шинжилгээний ажлын хүрээнд экспортын бодит орлогыг тодорхойлохын тулд дараах тоон мэдээлэл, статистикийг ашигласан.

- Гадаад валютын урсгалын мэдээ (Монголбанк)
- Төлбөрийн тэнцлийн статистик (Монголбанк)
- Гадаад худалдааны барааны статистикийн мэдээний бааз (ГЕГ)
- Экспортын гол 10 нэр төрлийн барааны гүйцэтгэлийг аж ахуйн нэгжээр (ГЕГ)
- ААНБ-уудын төлбөрийн тэнцлийн мэдээ (ААНБ)
- ААНБ-уудын санхүүгийн тайлан баланс (Сангийн яам)
- Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний жишиг үнийн мэдээлэл (Уул уурхайн яам)


2. АРГАЧЛАЛ, ТООЦООЛОЛ

2.1 Шинжилгээний ерөнхий аргачлал

Экспортын бодит орлогыг тодорхойлохдоо дараах шат дарааллаар шинжилгээг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Голлох 10 экспортын бараа бүтээгдэхүүний хувьд гаалийн мэдүүлэг тус бүрийн статистик дүн нь тухайн мэдүүлэг дэх гэрээний дүнтэй нийцтэй байгаа эсэхийг тулгаж, хэлцлийн үнийн аргаар мэдүүлэг бүртгэгдсэн эсэхийг шалгана.
2. Хэрэв статистик дүн болон гэрээний дүн нь хоорондоо нийцгүй байвал гаалийн үнийг тодорхойлохдоо хэлцлийн үнийн аргаас бусад арга хэрэгслийг ашигласан болох нь тодорхойлогдох ба энэ тохиолдолд төлбөрийн тэнцлийн барааны дансанд тухайн бараа бүтээгдэхүүнийг бүртгэхдээ тохируулга хийх шаардлагатай болно.
3. Дараа нь гаалийн статистик дүн болон гэрээний дүнгийн аль нь тухайн байгууллагын бодит валютын урсгалтай нийцтэй байгааг арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлангийн гүйлгээний дүнтэй тулган үзнэ.
4. Мөн гаалийн статистик дүн болон гэрээний дүнгийн аль нь тухайн байгууллагын бодит орлоготой нийцтэй байгааг тухайн ААНБ-ын санхүүгийн тайлан мэдээ, төлбөрийн тэнцлийн мэдээтэй тулган үзнэ.
5. Гэрээ нь бараа нийлүүлэх аль нөхцөлөөр хийгдсэнээс хамааран гэрээний дүнд тохируулга хийх шаардлагатай болно. Тухайлбал экспортын гэрээ нь EXW буюу уурхайн ам нөхцөлөөр хийгдсэн тохиолдолд гэрээний дүнд хилийн боомт хүртэлх тээврийн зардлыг нэмж тооцно.
6. Дээрх үзүүлэлтүүдийг харгалзаж үзсэний үндсэнд тухайн мэдүүлгийн эцсийн дүнг тодорхойлж, төлбөрийн тэнцлийн барааны дансанд бүртгэх тоон мэдээллийг бүрдүүлнэ.

Схем 2: Шинжилгээний шат дараалал



2.2 Тооцоолол

Монголбанк, Гаалийн ерөнхий газрын хамтран ажиллах журам¹⁸⁰-ын хүрээнд Монголбанк нь экспортын гадаад худалдааны голлох 10 бүтээгдэхүүний¹⁸¹ мэдээллийг ААН-ийн задаргаагаар авдаг ба эдгээр бүтээгдэхүүнүүд нь нийт экспортын 94.2%-ийг бүрдүүлж, эх олонлогийг хангалттай түвшинд тайлбарлаж байна.

Шинжилгээний шат дараалал 1-2:

2011 оны эхнээс 2014 оны 8 дугаар сар хүртэлх хугацааны экспортын мэдүүлгийн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн үзвэл голлох нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийн гаалийн үнэлгээ нь хүснэгт 1-д тусгасан аргачлалаар бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл зэсийн баяжмал, түүхий нефть, цэвэршүүлээгүй алт болон молибдений баяжмалын үнэлгээг хэлцлийн буюу гэрээний үнийн дагуу бүртгэдэг бол ямааны угаасан, самнасан ноолуурын хувьд холимог хэлбэрээр аргачлалуудыг ашигладаг боловч үүнээс үүдэн үүсэх зөрүү дүн бага байна. Иймд дээрх бүтээгдэхүүнүүдийн хувьд гаалийн статистик дүнгээр төлбөрийн тэнцлийн барааны дансанд бүртгэх, тохиргоо бичилт хийхгүй байх боломжтой юм.

Хүснэгт 1: Голлох экспортын бүтээгдэхүүний гаалийн үнэлгээний аргачлал

Үнэлгээний аргачлал	Бүтээгдэхүүний төрөл	Төлбөрийн тэнцэлд хэрхэн бүртгэх
Хэлцлийн үнийн арга	Зэсийн баяжмал, түүхий нефть, цэвэршүүлээгүй алт, молибдений баяжмал	Гаалийн статистик дүнгээр бүртгэх
Холимог аргаар боловч гэрээний дүнтэй зөрүү бага	Ямааны угаасан, самнасан ноолуур	Гаалийн статистик дүнгээр бүртгэх
Зах зээлийн жишиг үнийн аргаар	Жонш, цайр, төмрийн хүдэр, чулуун нүүрс	Тохируулга хийж бодит орлогыг тусгах

Харин жонш, цайрын баяжмал, төмрийн хүдэр болон чулуун нүүрсний хувьд гаалийн статистик дүн болон гэрээний дүнгийн зөрүү өндөр¹⁸² байсан тул цаашид нарийвчлан задалж үзэх шаардлагатай гэж үзсэн.

¹⁸⁰ Монголбанкны Ерөнхийлөгч, Гаалийн ерөнхий газрын даргын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А-119/А/132 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн батлагдсан.


¹⁸¹ Чулуун нүүрс (2701), Зэсийн баяжмал (2603), Төмрийн хүдэр ба баяжмал (2601), Боловсруулаагүй нефть (2709), Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт (7108), Цайрын хүдэр ба баяжмал (2608), Молибдений хүдэр ба баяжмал (2613), Жонш, лейцит, нефелинт ба нефелинт сиенит (2529), Ямааны угаасан ноолуур (5102), Ямааны самнасан ноолуур (5105).

¹⁸² Жилийн нийт зөрүү нь 10 саяас дээш дүнг өндөр зөрүү гэж авч үзсэн болно.

Шинжилгээний шат дараалал 3-4:

Цайрын баяжмал, төмрийн хүдэр, чулуун нүүрсний экспортын гаалийн статистик дүнг гаалийн мэдүүлэгт тусгагдсан гэрээний дүн, гадаад гүйлгээний тайлангийн экспортын орлогын дүнтэй харьцуулж үзэхэд /Зураг 2/ төмрийн хүдэр болон цайрын баяжмалын хувьд гэрээний дүн нь гаалийн экспортын бүртгэлээс 2011 онд 17%-иар, 2012 онд 35%-иар, 2013 онд 37-41%-иар, 2014 оны эхний 8 сард 30-38%-иар бага байгаа нь тогтоогдсон. Түүнчлэн дээрх зөрүү дүнг голлох ААН-ийн түвшинд нарийвчлан задалж үзэхэд ААН-ийн санхүүгийн тайланд тусгагдсан мөнгөн гүйлгээний орлого нь мэдүүлэг дэх гэрээний дүнтэй нийцтэй байгаа нь харагдсан.

Зураг 2. Гаалийн статистик дүн, гаалийн мэдүүлэгт тусгагдсан гэрээний дүн болон гадаад гүйлгээний тайлан дахь тухайн бүтээгдэхүүний экспортын орлогын харьцуулалт /2011- 2014 эхний 8 сар/



Эдгээр бүтээгдэхүүнүүдийн гаалийн үнэлгээг тооцоолохдоо экспортын гаалийн үнэлгээний 4-р аргачлал буюу зах зээлийн мэдээлэлд үндэслэсэн байна. Манай улсад баримтлах албан ёсны зах зээлийн үнийн мэдээллийг Уул уурхайн яамнаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах¹⁸³ зорилгоор сар бүр олон нийтэд мэдээлдэг ба ингэхдээ Хүснэгт 2-т тусгасан эх сурвалжийг ашиглан тооцдог байна.

Хүснэгт 2. Голлох бүтээгдэхүүнүүдийн зах зээлийн үнэ тогтоох аргачлал

Эх сурвалж		Тухайн сарын жишиг үнэ тодорхойлох
Цайрын баяжмал	Лондонгийн металлын бирж дээрх цэвэр цайрын үнэ http://www.umetal.com	Өмнөх сарын дундаж үнээр
Төмрийн хүдэр	Австралийн төмрийн хүдэр үйлдвэрлэгчдээс Хятадын ган үйлдвэрлэгчид нийлүүлж байгаа Dampeir/Hedland боомтын FOB үнэ	Өмнөх сарын дундаж үнээр
Чулуун нүүрс	http://en.sxcoal.com/	Өмнөх сарын дундаж үнээр

Засгийн газрын тогтоолын дагуу жишиг үнэ тооцох аргачлалыг Татварын

¹⁸³ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлээр зохицуулагддаг.

ерөнхий газар баталсан бөгөөд уг аргачлалд зааснаар¹⁸⁴ экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний агууламжийг Гаалийн төв лабораторийн дүгнэлтэд үндэслэн жишиг үнийг хямдруулж тооцон, борлуулалтын үнэлгээг гаргадаг.

Тухайлбал цайрын баяжмалын экспортын 95 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг Цайрт минерал ХХК нь 50% хүртэл агууламжтай цайр баяжуулах хүчин чадалтай бөгөөд гаалийн статистикт ашиглагдсан зах зээлийн үнэлгээ нь тодорхой хугацааны ачилт дахь цайрын баяжмалын агууламжийг Лондонгийн металлын бирж дээрх цэвэр цайрын үнээр үржүүлсэн дүнтэй ижил байна. Өөрөөр хэлбэл тухайн байгууллага цайраа ямар үнээр борлуулж байгаагаар бус, харин олон улсын зах зээл дээр ямар үнээр арилжаалагдаж байгаагаар жишиг татвар төлүүлэх зохицуулалттай байдаг бол гаалийн статистикт мөн энэ зарчмаар бүртгэгдсэн байна.

Энэхүү “зах зээлийн мэдээлэл”-д үндэслэх үнэлгээний аргачлал нь баяжмалаас цэвэр бүтээгдэхүүн боловсруулах зардал, холбогдох бусад татвар хураамжийн үнийг оролцуулсан үнэлгээ тул экспортын дүнг хэт өндрөөр харуулж байна.

Шигтгээ 2: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)

АМНАТ нь хууль эрхзүйн хувьд доорх зарчмаар тодорхойлогддог:

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл:

47.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлнө.

47.2. Энэ хуулийн 47.1-д заасан борлуулалтын үнэлгээг дараахь журмаар тооцно:

47.2.1. экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

Нүүрсний АМНАТ:

Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолд нүүрсний жишиг үнийг тогтоохдоо Хятадын www.coalworld.net цахим хуудаст тавигдсан үнийг баримтлахаар заасан байдаг. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилготой 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу жишиг үнэ тооцох аргачлалыг Татварын ерөнхий газраас батлан мөрдүүлж ирсэн.

Засгийн газрын 2012 оны 10 сарын 6-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор нүүрсний жишиг үнийн аргачлалыг өөрчлөлт оруулж, жишиг үнийг “...Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нүүрс борлуулж, экспортод гаргах гэрээний үнэ...” болгон өөрчилж, 2013 оны 4 сарын 1-ний өдрийг хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн ба энэ хугацаанд жишиг үнэ тооцох шинэ аргачлал боловсруулахыг холбогдох байгууллагад үүрэг болгосон.

Тогтоолд заасан хугацаа дуусгавар болж, Сангийн яамны санаачлагаар жишиг үнийн эх сурвалжийг www.coalworld.net сайтаас www.sxcoal.com руу шилжүүлсэн.

Засгийн газрын 2014 оны 3 сарын 21-ний өдрийн 88, 89 дүгээр тогтоолуудаар 2015 оны 1 сарын 1-ний өдрийг хүртэл нүүрсний экспортод гэрээний үнийг суурилож АМНАТ ногдуулахаар шийдвэрлэсэн нь одоогоор дагаж мөрдөгдөж байна.


¹⁸⁴ Засгийн газрын 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу жишиг үнэ тооцох аргачлалыг Татварын ерөнхий газрын 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 322 дугаар тушаалаар батласан

Шинжилгээний шат дараалал 5:

Гадаад худалдаанд худалдах, худалдан авах гэрээ байгуулахад талуудын сонгосон Инкотермс-ийн бараа нийлүүлэх суурь нөхцөлөөс хамаарч зардал, эрсдэлийг хариуцах тал тогтоогддог ба энэ нь барааны үнэ бүрдэлтэд шууд нөлөөлдөг.

Шинжилгээний өмнөх үе шатуудад дурдсанчлан чулуун нүүрс, төмрийн хүдэр, цайрын баяжмал болон жоншны экспортын гаалийн статистик дүн нь “зах зээлийн мэдээлэл”-ийн үнэлгээний аргачлалаар буюу бодит экспортын гэрээний дүнгээс өөр зарчмаар бүртгэгдсэн болох нь тогтоогдсон. Иймд Төлбөрийн тэнцэлд тусгах экспортын дүнг гэрээний дүнд үндэслэн тодорхойлох, ингэхдээ гэрээний бараа нийлүүлэх нөхцөлөөс хамааран гэрээний дүнд тохируулга хийх шаардлага гарсан.


Зураг 3. Бараа нийлүүлэх Инкотермс нөхцөл, 2010 он




Тухайлбал экспортын гэрээ нь EXW буюу уурхайн ам нөхцөлөөр хийгдсэн тохиолдолд гэрээний дүнд хилийн боомт хүртэлх тээврийн зардлыг нэмж тооцох хэрэгтэй болсон.

Зураг 4. 2011 оноос хойшхи бараа нийлүүлэх нөхцөл, бүтээгдэхүүний тоо хэмжээний жингээр


1. Цайрын баяжмал



2. Төмрийн хүдэр



3. Чулуун нүүрс



Цайрын баяжмал, төмрийн хүдэр: Экспортын гэрээний дийлэнх нь хил хүртэлх тээвэр орсон нөхцлүүдээр хийгдсэн тул гэрээний дүнг DAP, DAF, DAT нөхцлүүдийн хувьд хэвээр нь авч, бусад хэлцлүүдийн хувьд аливаа таамаглал дэвшүүлэхээс зайлсхийсэн тул гаалийн статистик дүнгээр авч ашигласан.

Чулуун нүүрс: Хилийн боомт хүртэлх нөхцөлөөр гэрээний 50 орчим хувь нь хийгдэж, үлдсэн тал хувь нь уурхайн ам нөхцөл (EXW), тээвэрлэх хүртэл нэрлэсэн газар (FCA, CPT) зэрэг нөхцөлүүдээр хийгдсэн байна. Иймд EXW, FCA, CPT нөхцөлүүдийн хувьд холбогдох зардлуудыг нэмж тохиргоо хийх шаардлагатай болсон. Ингэхдээ дараах зарчмуудыг баримталж бодит тээвэр, холбогдох бусад зардлуудын дүнг тоймлон тусгалаа:


- Ижил төстэй бүс нутагт орших бусад уурхайн тээвэр, нэмэгдэл зардлын дүнгээр баримжаалах (тухайлбал Монголын алт МАК ХХК-ын мэдүүлэг дэх дундаж зардлаар Чинхуа МАК Нарийнсухайт ХХК-ын экспортын дүнд тохиргоо хийх)
- Өмнө хийгдсэн нүүрсний судалгааны ажлууд дахь тээврийн зардлын тойм¹⁸⁵
- ААНБ-уудаас авсан тээврийн зардалтай холбоо бүхий албан мэдээллүүд.

Шинжилгээний шат дараалал 6:


Бараа нийлүүлэх нөхцлийн тохиргоо хийгдсэн Төлбөрийн тэнцэлд ашиглах бодит экспортын дүнг тодорхойлсон. Үр дүнг ойлгомжтой харуулах зорилгоор нэгж бүтээгдэхүүнд ногдох экспортын үнээр судалгааны үр дүнг танилцууллаа:

¹⁸⁵ Renaissance capital (2011). Moncolia, Mongolian coal and infrastructure


Зураг 5. Цайрын баяжмалын (ам.доллар/тонн)



Зураг 6. Төмрийн хүдрийн үнэ (ам.доллар/тонн)



Зураг 7. Чулуун нүүрсний үнэ (ам.доллар/тонн)



Зураг 7-оос чулуун нүүрсний хилийн үнэ болон гэрээний үнийн зөрүү нь хугацааны цувааны турш жишиг үнэ тогтоох аргачлалын өөрчлөлттэй уялдан хэлбэлзэж ирсэн нь харагдаж байна. 2012 оны 10 сараас 2013 оны 4 сар хүртэл¹⁸⁶, 2014 оны 4 сараас 2015 оны 1 сарыг хүртэл¹⁸⁷ хугацаанд зах зээлийн жишиг үнийг гэрээний үнэд үндэслэн тогтоож байсан нь тус хугацаануудын нүүрсний экспортын хилийн дундаж үнийг огцом бууруулж байсан байна.

¹⁸⁶ Засгийн газрын 2012 оны 10 сарын 6-ны өдрийн 74 дүгээр тогтоол

¹⁸⁷ Засгийн газрын 2014 оны 3 сарын 21-ний өдрийн 88, 89 дүгээр тогтоолууд

ҮР ДҮН

Шинжилгээний үр дүнд гадаад худалдааны статистик мэдээлэл дэх экспортын бүртгэл нь 2011 оны эхнээс 2014 оны 8 сар хүртэлх хугацаанд 1,869.8 сая ам.доллараар илүү үнэлэгдсэн нь тогтоогдлоо.

Манай оронд гадаад худалдааны статистик мэдээллийг боловсруулах эрх, үүргийг хуулийн дагуу Гаалийн ерөнхий газар хариуцдаг бөгөөд статистик мэдээллийг гаалийн мэдүүлэгт үндэслэн боловсруулдаг. Хэрэв гаалийн мэдүүлэг нь бүрэн бус, дэлхийн зах зээл дээх үнэлгээнээс хэт доогуур тавигдсан гэж үзсэн тохиолдолд гаалийн байгууллага нь үнэлгээний бусад арга хэрэгслүүд /Шигтгээ 1/-ийг ашиглаж үнийн дүнг тодорхойлон, статистикийг нэгтгэдэг.


Бүтээгдэхүүн	2011			2012			2013			2014		
	Гааль (хуучин)	МБ (шинэ)	ITRS	Гааль (хуучин)	МБ (шинэ)	ITRS	Гааль (хуучин)	МБ (шинэ)	ITRS	Гааль (хуучин)	МБ (шинэ)	ITRS
Нүүрс	2,262	1,605	1,643	1,880	1,543	1,233	1,116	1,044	852	578	572	269
Төмрийн хүдэр	442	368	270	533	350	304	654	395	341	288	203	156
Цайрын баяжмал	143	120	109	131	85	94	119	75	92	76	47	42
Бусад	1,971	1,965	1,913	1,841	1,827	2,052	2,379	2,358	1,718	2,634	2,621	1,602
Нийт	4,817	4,058	3,935	4,385	3,805	3,683	4,269	3,872	3,004	3,576	3,442	2,070

Шинжилгээний ажлаар чулуун нүүрс, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонш гэсэн 4 бүтээгдэхүүний гаалийн үнэлгээг тооцохдоо “зах зээлийн мэдээлэл”-д үндэслэх үнэлгээний аргачлалыг ашигладаг нь батлагдсан.

2011, 2012 онуудад чулуун нүүрсний экспортын бүртгэл хэт өндрөөр үнэлэгдэж байсан бол 2012 оны төгсгөлөөс эхлэн тодорхой хугацаанд гаалийн үнэлгээг хэлцлийн үнийн аргачлал руу шилжүүлсэн, жишиг үнийн эх сурвалжийг сольсон зэргээс шалтгаалж уг зөрүү багасчээ.

Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2012, 2013 онуудад огцом өсөлттэй байсан тул үүнтэй холбогдуулан илүү бүртгэлийн хэмжээ өссөн байна.

Зураг 8. Экспортын илүү бүртгэл, бүтээгдэхүүнээр



Зураг 9. Төлбөрийн тэнцэл дэх барааны данс



ДҮГНЭЛТ

Төлбөрийн тэнцэл боловсруулах олон улсын аргачлалын дагуу төлбөрийн тэнцлийн барааны дансанд тусгах экспортын дүн мэдээ нь гаалийн байгууллагын аливаа үнэлгээний арга хэрэгслээс үл хамааран ААНБ-ын гэрээ, хэлцлийн дүн болон бодит орлогод үндэслэн гарч байх шаардлагатай байдаг.

Иймд Төлбөрийн тэнцлийн барааны дансны бүртгэлийг гүйцэтгэхдээ Гаалийн ерөнхий газраас бэлтгэн гаргадаг Гадаад худалдааны статистик мэдээлэлд холбогдох тохируулгыг хийж тусгах нь зүйтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

IMF, (1995). *Balance of payments Compilation guide*

IMF, (2009). *Balance of Payments and International investment position manual (Sixth edition)*

Renaissance capital (2011). *Moncolia, Mongolian coal and infrastructure*

Монголбанк. (2011-2014). *Банкуудын гадаад гүйлгээний тайлан*

Монголбанк. (2011-2014). *Монгол Улсын төлбөрийн тэнцэл*

Гаалийн ерөнхий газар. (2011-2014). *Гадаад худалдааны статистик мэдээлэл*

Гаалийн тариф, татварын тухай Монгол Улсын хууль

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хууль

Гаалийн ерөнхий газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Заавар батлах тухай 573 дугаар тушаал

Жишиг үнэтэй холбоо бүхий Засгийн газрын тогтоолууд